

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/2/НА-СТА-ТӨХК

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Буян-Ундрах Утас: 70357955 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: В.Жавзмаа Утас: 70350757 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Бямбатогтох Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn Аудитор: Д.Цогбадрах Утас: 70355805 Цахим хаяг: tsogbadrakhd@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
4. Аудитын тайлан	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Дотоод хяналт	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
4.4 Материаллаг байдал	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
8. Аудитын илрүүлэлт.....	15
8.1 Залруулсан алдаа.....	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага.....	15
8.4 Зөвлөмж.....	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл

1.Аудитын санал дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.14 № 95
танай _____-ны № _____-г

ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй зээлээр барьсан өргөтгөлийн ажил дуусаж, ашиглаж эхэлсэн боловч хөрөнгийг бүртгээгүй, зээлийн төлөлтийн талаарх шийдвэрийг ирүүлээгүй байна.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 12 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Цахилгаан болон дулаан эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлт 101.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрх болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүчний төлбөрийг зохих журмын дагуу төрөөс хариуцан төлөх болсонтой холбоотой эрчим хүчний хэрэглээ өссөн байна.

Нийт орлого төлөвлөснөөс 3,346.3 сая төгрөг буюу 106.7 хувиар давсан бөгөөд төлөвлөсөн цахилгаан эрчим хүчний түгээлт 7.2 хувь, дулааны эрчим хүчний борлуулалт 6.8 хувиар өссөн, үйл ажиллагааны бус орлого нэмэгдсэнтэй холбоотой.

Нийт зардлын гүйцэтгэл 94.6 хувьтай, 2,838.3 сая төгрөгийг хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны зардалд хэмнэлт гаргасан байна.

Хөрөнгө оруулалтаар нийт 81 ажилд 8,583.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, 95.7 хувийн гүйцэтгэлтэй, 445.2 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,059,411,683.13	309,549,506.35
1.1.2	Дансны авлага	3,584,343,053.29	5,709,058,428.32
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	488,768.89
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	3,277,531,634.22	2,402,190,286.39
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,143,795,944.78	1,031,898,718.16
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,065,082,315.42	9,453,185,708.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	63,472,763,972.12	63,262,732,758.52
1.2.2	Биет бус хөрөнгө	21,167,067,099.32	21,116,509,267.61
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	171,009,003.10
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	84,639,831,071.44	84,550,251,029.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	93,704,913,386.86	94,003,436,737.34
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	898,983,325.76	1,907,792,482.39
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	1,509,046.54	163,784,593.69
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүгийн өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	120,051,286.45	352,496,872.21
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,797,922.15	288,826,158.76
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,024,341,580.90	2,712,900,107.05
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	5,469,411,697.62	4,106,806,471.32
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,469,411,697.62	4,106,806,471.32
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,493,753,278.52	6,819,706,578.37
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	19,447,456,792.53	19,447,456,792.53
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	59,135,050,898.37	59,135,050,898.37
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	20,937,713,000.00	20,937,713,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-12,309,060,582.56	-12,336,490,531.93
2.3.11	Эздийн өмчийн дүн	87,211,160,108.34	87,183,730,158.97
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	93,704,913,386.86	94,003,436,737.34

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	41,134,179,660.78	48,429,590,764.60
2	Борлуулалтын өртөг	36,888,813,263.86	44,655,284,099.89
3	Нийт ашиг (алдагдал)	4,245,366,396.92	3,774,306,664.71
4	Түрээсийн орлого	33,210,021.64	36,896,083.09
5	Хүүгийн орлого	56,649,316.11	3,320,043.14
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	1,513,545,811.58	1,559,102,984.47
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,829,568,245.69	3,909,124,979.60
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,169,811,350.66	1,207,931,213.95
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	255,987,393.31	196,095,695.75
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	593,404,556.59	60,473,886.11
19	Орлогын татварын зардал	49,908,272.86	6,379,392.92
20	Татварын дараах ашиг (алдагдал)	543,496,283.73	54,094,493.19
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	543,496,283.73	54,094,493.19
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	543,496,283.73	54,094,493.19
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,734,205,000.00	-12,753,777,998.05	86,562,934,692.85
Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,734,205,000.00	-12,753,777,998.05	86,562,934,692.85
Бусад дэлгэрэнгүй орлого			203,508,000.00		203,508,000.00
Өмчид гарсан өөрчлөлт				-14,615,736.80	-14,615,736.80
Зарласан ногдол ашиг				-84,163,131.44	-84,163,131.44
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				543,496,283.73	543,496,283.73
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	-12,309,060,582.56	87,211,160,108.34
Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	-12,309,060,582.56	87,211,160,108.34
Зарласан ногдол ашиг				-81,524,442.56	-81,524,442.56
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				54,094,493.19	54,094,493.19
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	-12,336,490,531.93	87,183,730,158.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31	
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	40,188,099,648.63	45,372,062,749.31	
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	40,103,754,195.74	45,225,456,359.02	
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00	
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00	
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	84,345,452.89	146,606,390.29	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-35,216,186,957.67	-43,318,724,601.00	
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-9,233,046,806.08	-9,286,234,756.50	
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-3,107,600,000.00	-3,246,727,644.86	
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-12,840,581,102.60	-17,078,258,714.46	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-1,854,015,616.02	-1,453,671,545.21	
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-5,365,421,258.01	-9,817,039,701.11	
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	0.00	0.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-2,776,258,311.86	-2,293,050,166.19	
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-9,999,566.84	-9,920,985.19	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-29,264,296.26	-133,821,087.48	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,971,912,690.96	2,053,338,148.31	
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	56,649,316.11	3,253,082.01	
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00	
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00	
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00	
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00	
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	56,649,316.11	3,253,082.01	
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-4,652,207,526.60	-2,724,928,964.54	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-4,629,208,822.60	-2,722,128,964.54	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-22,998,704.00	-2,800,000.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-4,595,558,210.49	-2,721,675,882.53	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00	
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00	
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00	
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	0.00	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-84,163,131.44	-81,524,442.56	
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	0.00	
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00	
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00	
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-84,163,131.44	-81,524,442.56	
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	0.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-84,163,131.44	-81,524,442.56	
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	292,191,349.03	-749,862,176.78	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	767,220,334.10	1,059,411,683.13	
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,059,411,683.13	309,549,506.35	

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэсэн: ЦЭХ		сая.квтц	158.2	265.5	271.0	5.5	101.2
	Үйлдвэрлэсэн: ДЭХ		мян.Гкал	620.3	651.0	657.8	6.8	
	Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим	Хувиар	хувь	18.5%	15.8%	14.9%	-1.0%	
		Биетээр	сая.квтц	29.2	42.0	40.3	-1.7	
	Түгээсэн: ЦЭХ		сая.квтц	129.0	223.5	230.8	7.2	
	Түгээсэн: ДЭХ		мян.Гкал	589.6	612.1	616.0	3.8	
2	Нийт орлого		сая.төг	42,737.6	46,682.6	50,028.9	3,346.3	107.8
	Үүнээс:	Цэвэр борлуулалт	сая.төг	41,134.2	45,215.1	48,429.6	3,214.5	
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	1,603.4	1,467.5	1,599.3	131.8	
3	Нийт зардал		сая.төг	42,144.2	52,806.7	49,968.4	(2,838.3)	100.0
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	41,888.2	52,489.5	49,772.3	(2,717.2)	
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	256.0	317.2	196.1	(121.1)	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	593.4	(6,124.1)	60.5	6,184.6	100.0
5	Татварын дараах ашиг/алдагдал		сая.төг	543.5	(6,124.6)	54.1	6,178.7	100.0
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.0	1.1	1.0	(0.13)	100.0
7	Нийт авлага		сая.төг	3,584.3	6,429.0	5,709.1	(719.9)	100.0
	Үүнээс:	ЭХ-ний	сая.төг	3,570.2	6,408.0	5,705.5	(702.5)	
		бусад	сая.төг	14.1	21.0	3.5	(17.5)	
8	Нийт өглөг		сая.төг	6,493.8	153,258.6	6,819.7	(146,438.9)	100.0
	Үүнээс:	БХӨТ	сая.төг	1,024.3	5,781.7	2,712.9	(3,068.8)	
		УХӨТ	сая.төг	5,469.4	147,476.9	4,106.8	(143,370.1)	
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	450	450	450	0	100.0
10	Нийт цалингийн сан		сая.төг	11,608.22	11,650.7	11,617.7	(33.0)	100.0
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	ЦЭХ	гр/кВт.ц	336.5	368.4	368.4	-0.01	100.0
		ДЭХ	кг/Гкал	186.5	187.6	187.4	-0.19	
12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		сая.төг	4,385.1	7,092.9	5,163.3	(1,929.6)	100.0

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн зорилго нь хэрэглэгчийг дулаан, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан үйлдвэрлэх;
- Дулаан үйлдвэрлэх;
- Дулаан түгээх;
- Дулаанаар зохицуулалттай хангах;
- Эрчим хүчний тоног төхөөрөмж, даралтат сав шугам хоолойг ашиглах, засвар үйлчилгээ хийх;
- Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компанийн статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 70 хувь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 30 хувийг эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийг Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 164 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь заалтуудтай нийцэж байна.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 101.7 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Эрчим хүчний яам, ТӨБЗГ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3.-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн

байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, орон тоо болон цалин хөлсийг нэмэгдүүлээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн тэтгэврийн даатгал-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, тэтгэврийн даатгал-даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, шимтгэлийн дүн-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, шимтгэлийн дүн-даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсөн.
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолд 2021 оны 207 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж 1 дэх заалтын “7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл” гэснийг “12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал” гэж өөрчилсөн.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,059.4	309.5	-749.9
Авлага	3,584.3	5,709.6	2,125.3
Урьдчилгаа	1,143.8	1,031.9	-111.9
Бараа материал	3,277.5	2,402.2	-875.3
Үндсэн хөрөнгө	63,472.8	63,262.7	-210.1
Биет бус хөрөнгө	21,167.1	21,116.5	-50.6
Хойшлогдсон татварын хөрөнгө	0.0	171.0	171.0
Нийт хөрөнгийн дүн	93,704.9	94,003.4	298.5
Өр төлбөрийн дүн	6,493.8	6,819.7	325.9
Богино хугацаат өглөг	1,024.4	2,712.9	1,688.5
Урт хугацаат өглөг	5,469.4	4,106.8	-1,362.6
Эздийн өмч	87,211.1	87,183.7	-27.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	93,704.9	94,003.4	298.5

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Банк дахь мөнгөний үлдэгдэл 303.8 сая төгрөг болж өмнөх оноос 749.9 сая төгрөгөөр буурсан байна.

Авлагын үлдэгдэлд ХАОАТ-ын авлага 0.5 сая төгрөгийг эзэлж байна. Тайлант онд цахилгаан эрчим хүчний борлуулалтын хүрээнд үүссэн Диспетчерийн үндэсний төвөөс авах авлага 2,259.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ. Авлагын үлдэгдэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжсэн 4 байгууллагаас авах 27.7 сая төгрөгийн авлага байна.

Тайлант онд хөрөнгө оруулалт, их засварын ажлын төлбөрт 3,649.0 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 130.3 сая төгрөгийн ажил СС-35МВт-ын турбин генератор өргөтгөлийн ажилтай холбоотой хойшилж, дуусаагүй байна. Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 2,488.1 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,402.2 сая төгрөг болж 875.3 сая төгрөгөөр буурсан нь хангамжийн материал, тосолгоо, тээврийн хэрэгслийн сэлбэг, хими, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бараа материалууд өсөж, нүүрс, мазут, үндсэн сэлбэг хэрэгсэл, шатахууны үлдэгдэл буурснаас шалтгаалжээ. Тайлант онд худалдан авалтаар 20,568.4 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн ба үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал байхгүй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд 5-аас дээш жилийн насжилттай 908 нэр төрлийн удаан хугацаанд эргэлтэд ордог сэлбэг материалууд байдаг бөгөөд техник технологийн шинэчлэл, өөрчлөлттэй холбоотойгоор ашиглах боломжтой эсэхийг тайлант онд тогтоосон байна. Оны эцэст 12 сард 2,720.8 сая төгрөгийн нүүрс худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн ба 9 хоногийн нөөц байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Шинээр 620.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, дуусаагүй барилга, их засварын зардал 802.9 сая төгрөгөөр, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулсан 1,298.3 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 144.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 6,107.5 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан байна. Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 102, А/1/577 дугаар тогтоолоор нийт 144.3 сая төгрөгийн өртөгтэй, 144.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 46 ширхэг хөрөнгийг акталжээ.

Биет бус хөрөнгө 50.6 сая төгрөгөөр буурсан нь компьютерын программ хангамж данснаас хасаж, элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь 3,175.3 сая төгрөг болж өмнөх оноос өссөн нь гэрээт ажлуудаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 1,907.8 сая төгрөгийн дансны өглөг, 163.8 сая төгрөгийн татварын өр, 288.8 сая төгрөгийн бусад өр төлбөр, 352.5 сая төгрөгийн урьдчилж орсон орлого байна. Урт хугацаат өр төлбөрийн хойшлогдсон орлого дансанд 2015-2019 онд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 3 ажлын 7,941.3 сая төгрөгийг бүртгэж, 3,834.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлээр орлогыг хүлээн зөвшөөрч, 4,106.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт компанийн тайлант хугацаанд гарсан өртөг, зардлыг ашиглалт, засвар, үйлчилгээ, ерөнхий удирдлага, борлуулалт маркетинг гэсэн өртгийн төвүүдэд аккруэл сууриар бодитой, үнэн зөв тооцож, тайлант хугацаанд нь зохистой ангилж, хуваарилж бүртгэх, үйл ажиллагааны бусад зардлыг аккруэл сууриар зөв, тооцож бүртгэхээр заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Борлуулалтын өртөг өмнөх онтой харьцуулахад 7,766.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь түлш, ус, элэгдэл, нийгмийн даатгалын шимтгэлийн гэх зэрэг зардлын өсөлтөөс шалтгаалсан байна. Өмнөх оноос борлуулалт, маркетингийн зардал 79.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалтын шимтгэл өсөлтөөс, ерөнхий ба удирдлагын зардал 38.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төслийн нэгжийн зардлаас тус тус шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үйлдвэрлэлийн үе шатны аргаар тооцож бүртгэх ба ашиглалтын болон засвар үйлчилгээний зардал гэж ангилах бөгөөд үйлдвэрлэлийн 8 цехийн зардлыг хамруулдаг байна. Харин үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлууд өртөгт хуваарилагдахгүй зардлууд байна. Эдгээрийг НББ-ийн бодлогын баримт бичигт тодорхой тусгасан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/11 дүгээр тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 47,258.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 53,253.3 сая төгрөгөөр, 5,995.3 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 7,092.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын 2021 оны А/203 дугаар тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг тодотгохдоо нийт орлогыг 575.4 сая төгрөг, нийт зардлыг 446.6 сая төгрөг, алдагдлыг 129.3 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Гүйцэтгэлээр 50,028.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 49,968.4 сая төгрөгийн зардал гарган, 54.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 50,028.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 3,346.3 сая төгрөг буюу 6.7 хувиар давсан бөгөөд төлөвлөсөн цахилгаан эрчим хүчний түгээлт 7.2 хувь, дулааны эрчим хүчний борлуулалт 6.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 49,968.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,838.3 сая төгрөг буюу 5.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь 23 нэр төрлийн зардлаас 20 нэр төрлийн зардлын хэмнэлт гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 75 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 5,163.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 6,178.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн хэдий ч 54.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 228 дугаар тогтоолын дагуу тайлант онд 81.5 сая төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлэхээс 81.5 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна. Мөн түрээсийн төлбөрийн 40 хувь болох 22.1 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлжээ.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардал, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Буян-Ундрах, В.Жавзмаа, аудитор Б.Бямбатогтох, Д.Цогбадрах нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь 2021 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 4/109 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн үед мөрдөгдөж байсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байсан хэдий ч 2016-2021 онд шинэчлэгдсэн хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байна.

Тайлант онд тус байгууллагын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл болон санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд байгууллагаас хяналт, шалгалт хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын хэлтсийн дотоод аудитор тайлант онд аудитын 4 чиглэлийн 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажлын төлөвлөгөө боловсруулсан хэдий ч 1-9 сарын шилэн данс, өр авлагын харьцаа, барагдуулалт, анхан шатны баримтжуулалт, цалин бодолт зэргийг хянаж, санхүүгийн үйл ажиллагааг НББОУС-ын дагуу хөтөлж, тайланг хуулийн хугацаанд гаргаж хэвшсэн, зөрчилгүй гэж үнэлжээ.

Дотоод аудиторын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 19 арга хэмжээнээс компанийн 2021 оны зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд дотоод аудит хийгээгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан зарим чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 52,806.7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 1,056.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 739.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь тайлант онд нийт 94,901.4 сая төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 93,899.9 сая төгрөгийн 171 мэдээллийг мэдээлж, 1,001.5 сая төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүйг аудитын явцад залруулсан болно.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж байх, үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлж, хариуцлага тооцох зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин анхан шатны баримтыг хүчин төгөлдөр

баримтаар хөтлөөгүй, ТУЗ-аас баталсан их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй бараа материал худалдан авсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 13.6 дахь заалт, Сангийн сайдын 2017 онд баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, “Эрдэнэтийн дулаан цахилгаан станц” ТӨХК-ийн дүрмийн 8.11.9-д "компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх" гэсэн заалттай нийцээгүй байна.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 41.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	41.9	3	41.9			
Нийт дүн	3	41.9	3	41.9			

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тооцоолол, бүртгэл тайлагнал, урьдчилж орсон орлогын бүртгэл, олон жилийн насжилттай бараа материалын бодит үнэ цэнээр бүртгэсэн эсэхийг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,996.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, шилэн данстай холбоотой 1,001.5 сая төгрөгийн алдааг залруулж, 3.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 90.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,902.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 1,902.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 739.3 сая төгрөгийн түвшнээс 1,162.9 сая төгрөгөөр их байгаа хэдий ч үүнээс 1,647.6 сая төгрөгийн зөрчил нь материаллаг бус тул зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдааг залруулаагүй болно.

8.2 Төлбөрийн акт

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын үйлдвэрчний эвлэлийн хооронд байгуулсан хамтын гэрээг зөрчин зарим ажилтанд урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоов.

8.3 Албан шаардлага

Гүйцэтгэх захирлын 2021 оны Б/209 дугаар тушаалаар станцын хүчин чадлын СС35 МВт-н турбин генератораар өргөтгөх ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн нэрийдлээр нийт ажилчдыг хавтгайруулан урамшуулсан тул албан шаардлага хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

1. Цагийн бүртгэлийн дэвтэр, цаг бүртгэх төхөөрөмжийн бүртгэл зэрэг анхан шатны нотлох баримтуудад үндэслэлгүй 3 ажилтанд цалин олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 107.1-д "ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
2. Гүйцэтгэх захирлын Б/241 дүгээр тушаалыг үндэслэн үйлдвэрийн ахмад ажилтанд хамтын гэрээний 9.19 дэх заалтыг үндэслэн урамшуулал олгосон нь хамтын гэрээний 9.19-д "үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулсан, . . . , холбогдох ажилтнуудыг 200.0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулж болно." гэсэн заалтыг зөрчсөн байна.
3. Гүйцэтгэх захирлын тушаалаар хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд заагаагүй компанийн ойн өдрийн арга хэмжээний зардал гаргаж, ажилтнуудад бялуу бэлэглэсэн байна.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсөвт үндсэн цалингийн зардлыг баталсан байтал урамшуулал, шатахууны зардалд 3.6 сая төгрөг олгосон байна.
5. Тайлант хугацаанд 4.9 сая төгрөгийн гар утсыг худалдан авч, зарлагдсан нь Эрдэнэтийн дулаан цахилгаан станц" ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.2.4-д "Үндсэн хөрөнгө гэж нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм.", Эрдэнэтийн дулаан цахилгаан станц" ТӨХК-ийн дүрмийн 8.11.9-д "Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
6. Тайлант онд 11.2 сая төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Эрх бүхий байгууллагаас баталсан хууль, журам, хамтын гэрээг мөрдөн ажиллаж, дотоод хяналтыг сайжруулах.
2. Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төсөвт тавилга эд хогшил тусгахгүй байх.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тайлант оны эцэст бүртгэсэн өр төлбөрийн баталгаажуулалтыг харилцагч бүрээр баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
2. Тайлант оны эцэст бүртгэсэн зарим авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
3. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн 2015 оны 09 сарын 16-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан ба 2016 оноос хойш шинэчлэгдсэн, өөрчлөлт орсон хууль, журам, стандарттай нийцүүлж өөрчлөлт оруулаагүй байна.
4. Гүйцэтгэх удирдлага солигдох үед хөрөнгийн тооллого хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
5. Шаардах хуудсыг /НХМаягт БМ-6/ хүчингүй болсон маягтаар хөтөлж, бараа, материал хүлээн авалтын баримтыг /НХМаягт БМ-1/ огт хөтөлдөггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 3.1-д "Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирж байгаа бараа, материалын үнэ бүхий зүйлс, тоо хэмжээ, зэрэг дугаарын хувьд дагалдан ирсэн баримттайгаа тохирохгүй байх, хайрцаг, сав, баглаа боодол, лац, ломбо задарч гэмтсэн үед эд хариуцагч санхүүгийн албанд мэдэгдэж байгууллагаас мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй комисс томилуулж "Бараа, материал хүлээн авалтын баримт"-аар хүлээн авна. Комисс "Бараа, материал хүлээн авалтын баримт"-ыг асуултын дагуу 2 хувь нөхөн бичиж 1 хувийг дагалдан ирсэн баримтын хамт эд хариуцагчид, үлдэх хувийг тээвэрлэгчид өгнө.", Эд хариуцагч "Бараа, материал хүлээн авалтын баримт"-аар агуулахын бүртгэлийг хөтөлж тайлангийн хамт тайлант хугацаанд санхүүгийн албанд ирүүлнэ. Хариуцсан нягтлан бодогч хураангуй дансанд бичилт хийж баримтыг хадгална" гэсэн заалттай нийцэхгүй байна.
6. Хойшлогдсон татварын хөрөнгийг 171.0 сая төгрөгөөр бүртгэсэн байх боловч тооцоолсон ажлын хүснэгт, дэлгэрэнгүй тооцоололгүй байгаа нь Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн болон татварын үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам"-ын 3.9-д "хөрөнгө, өр төлбөр тус бүрийн хувьд татварын суурь, дансны үнийн дэлгэрэнгүй бүртгэлийг доорх хүснэгт 1-д тусгасан үлгэрчилсэн ажлын хүснэгтийг ашиглан тооцоолж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Компанийн НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдөгдөж буй хууль эрхийн актуудад нийцүүлэн өөрчлөлт оруулж, мөрдөх.

2. Хөрөнгө, өр төлбөрийг анхан шатны бүртгэлийн маягтыг хүчин төгөлдөр маягтаар хөтөлж баримтжуулан, тайланд тусгах, холбогдох албан тушаалтнуудын хариуцлагыг дээшлүүлэх.
3. Хойшлогдсон татварын хөрөнгийн дэлгэрэнгүй тооцоолол хийж, нягтлан 2022 оны эхний хагас жилийн тайланд залруулах.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 62,623.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь "Эрдэнэтийн дулаан цахилгаан станц" ТӨХК-ийн дүрмийн 8.11.9-д "Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Компанийн бизнес төлөвлөгөөг бодитой төлөвлөж, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт хийхгүй байх.

4. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тайлант онд нийт 94,901.4 сая төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 93,899.9 сая төгрөгийн 171 мэдээллийг мэдээлж, 1,001.5 сая төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүйг аудитын явцад залруулсан болно.

Өгсөн зөвлөмж:

1. Шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж байх, үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлж, хариуцлага тооцох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Б.БУЯН-УНДРАХ

В.ЖАВЗМАА

АУДИТОР

Б.БЯМБАТОГТОХ

Д.ЦОГБАДРАХ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК	ОРА-2022/2/НА-СТА-ТӨХК	Хамтын гэрээнд заасан шаардлага хангаагүй ажилтанд урамшуулал олгосон		1	1,732.1			1	1,732.1							
2			Хамтын гэрээнд заасан шаардлага хангаагүй ажилтанд урамшуулал олгосон		1	150.0			1	150.0							
3			Гүйцэтгэх захирлын 2021 оны Б/209 дугаар тушаалаар станцын хүчин чадлын СС35 МВт-ын турбин генератораар өргөтгөх ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн нэрийдлээр нийт ажилчдыг хавтгайруулан урамшуулсан		1	90,000.0					1	90,000.0					
4			ҮЭХ-ны даргад урамшуулал илүү олгосон		1	318.9			1	318.9							
5			Барилгын материалын худалдаа эрхэлдэг байгууллагаас гэрэл зураг, хүнсний худалдаа эрхэлдэг байгууллагаас ном худалдан авсан.		1	845.0			1	845.0							
6			1.Цагийн бүртгэлийн дэвтэр, цаг бүртгэх төхөөрөмжийн бүртгэл зэрэг анхан шатны нотлох баримтуудад үндэслэлгүй 3 ажилтанд цалин олгосон 2.Гүйцэтгэх захирлын Б/241 дугаар тушаалыг үндэслэн үйлдвэрийн ахмад ажилтанд хамтын гэрээний 9.19 дэх заалтыг үндэслэн урамшуулал олгосон 3.Гүйцэтгэх захирлын тушаалаар хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд заагаагүй	1. Эрх бүхий байгууллагаас баталсан хууль, журам, хамтын гэрээг мөрдөж ажиллаж, дотоод хяналтыг сайжруулах 2. Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төсөвт тавилга эд хогшил тусгахгүй байх.		2	20,930.9									2	20,930.9

		Компанийн төрсөн өдрийн баярт зориулж, ажилтнуудад торт бэлэглэсэн. 4.Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсөвт үндсэн цалингийн зардлыг баталсан байтал урамшуулал, шатахууны зардалд 3.6 сая төгрөг олгосон. 5.Тайлант хугацаанд гар утас худалдан авч, бараа материалын дансанд бүртгэж, шаардах хуудсаар шууд зарлагдсан. 6.Тайлант онд тавилга эд хогшил бэлтгэсэн байна.													
7		1.Тайлант оны эцэст бүртгэсэн өр төлбөрийн баталгаажуулалтыг харилцагч бүрээр баталгаажуулаагүй. 2.Тайлант оны эцэст бүртгэсэн зарим авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. 3.Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн 2015 оны 09 сарын 16-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан ба 2016 оноос хойш шинэчлэгдсэн, өөрчлөлт орсон хууль, журам, стандарттай нийцүүлж өөрчлөлт оруулаагүй байна. 4.Гүйцэтгэх удирдлага солигдох үед хөрөнгийн тооллого хийгээгүй байна. 5.Шаардах хуудсыг /НХМаягт БМ-6/ хүчингүй болсон маягтаар хөтөлж, бараа, материал хүлээн авалтын баримтыг /НХМаягт БМ-1/ огт хөтөлдөггүй байна. 6. Хойшлогдсон татварын хөрөнгө бүртгэсэн байх боловч тооцоолсон ажлын хүснэгт, дэлгэрэнгүй тооцоололгүй байна.	1.Компанийн НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдөгдөж буй хууль эрхийн актуудад нийцүүлэн өөрчлөлт оруулж, мөрдөх. 2.Анхан шатны бүртгэлийн маягтыг хүчин төгөлдөр маягтаар хөтөлж баримтжуулан, тайланд тусгах, холбогдох албан тушаалтнуудын хариуцлагыг дээшлүүлэх. 3.Хойшлогдсон татварын хөрөнгийн дэлгэрэнгүй тооцоолол хийж, нягтлан 2022 оны эхний хагас жилийн тайланд залруулах.	3	1,818,634.9								3	1,818,634.9	

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

8			Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийсэн	Компанийн бизнес төлөвлөгөөг бодитой төлөвлөж, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт хийхгүй байх	1	62,623.0										1	62,623.0
ДҮН					11	1,995,234.8			4	3,046.0	1	90,000.0				6	1,902,188.8
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
9			Тайлант онд нийт 94,901.4 сая төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 93,899.9 сая төгрөгийн 171 мэдээллийг мэдээлж, 1,001.5 сая төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүйг залруулсан.	Шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж байх, үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлж, хариуцлага тооцох	1	1,001,518.9		1,001,518.9								1	0
ДҮН					1	1,001,518.9		1,001,518.9									
НИЙТ ДҮН					12	2,996,753.7		1,001,518.9	4	3,046.0	1	90,000.0				7	1,902,188.8